


НЗЗ-НЫ 1 ДҮГЭЭР БАЙРНААС АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮНГИЙН ТУХАЙ


2018.12.14

Улаанбаатар хот

2018 оныг “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан НҮГазар нь “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил”-ын хүрээнд хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор “Таныг сонсьё” аяныг 2018 оны 11 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгуулж, тус аяны хүрээнд НЗЗ-ны 1-р байранд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдаас НҮГ-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг хаалттай 7, нээлттэй 1 асуултын хүрээнд явууллаа. Сэтгэл ханамжийн судалгаанд 39 ажилтан, албан хаагч хамрагдсан.

Дүнг нэгтгэн графикаар үзүүлбэл:





Тус сангал асуулгад оролцсон албан хаагчдаас дараах санал хүсэлт гаргасан байна.

- 00-ийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах - 2
- Цонх дулаалах - 2
- Дуудлага удаж ирдэг - 1
- Цайны газрын хоолноос үс гарсан - 1
- 1 давхарын 00-ийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах - 1
- 1, 2 давхарын 00-ийн өрөөнд ариун цэврийн цаас байдаггүй - 1
- Цайны газрын тогоочийн харилцаа муу - 3
- Хоолны амт чанарыг сайжруулах – 2
- Өглөөний цайны меню гаргах - 1
- Хоолны нэр төрлийг олшруулах - 1

Дүгнэлт

1. Өрөө тасалгаа болон нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 77% нь сайн, 23% нь дунд үнэлгээг тус тус өгсөн байгаа нь цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгааг харуулж байна.

2. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх асуулгад 50% нь сайн, 37% дунд, 13% хангалтгүй үнэлгээг тус тус өгсөн боловч хангалтгүй үнэлгээ өндөр гарч, өмнөх 1 үзүүлэлтээс үнэлгээ буурсан байгаа нь цаашид ариун цэврийн өрөөнүүдийн цэвэрлэгээнд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

3. Инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд судалгаанд оролцогчдын 79% сайн, 18% дунд, 3% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

4. Дуудлагын үйлчилгээний талаарх асуулгад санал асуулгад оролцогчдын 72% сайн, 26% дунд, 2% хангалтгүй үнэлгээг тус тус өгсөн.

5. Хурлын заалны тоног төхөөрөмжид судалгаанд оролцогчдын 79% сайн, 18% дунд, 3% хангалтгүй үнэлгээг тус тус өгсөн байна.

6. Цайны газрын хоолны нэр төрөл, амт чанарт 72% сайн, 23% дунд, 5% нь хангалтгүй үнэлгээг тус тус өгсөн байгаа нь сэтгэл хангалуун үзүүлэлт бага зэрэг буурсан харагдаж байна.

7. Цайны газрын орчин, нөхцөлд 46% сайн, 51% дунд, 3% хангалтгүй үнэлгээ өгсөн байгаа нь цайны газрын орчин нөхцөлд дундаж үнэлгээ өгсөн байна.

8. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд судалгаанд оролцогчдын 90% сайн, 10% нь дунд гэсэн үнэлгээ өгсөн.

9. Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд 95% нь сайн, 5% нь дунд гэсэн өндөр үнэлгээ өгсөн байгаа нь харагдаж байна.

Дээрхи асуултуудын хариултыг нэгтгэж үзвэл НҮГ-ын үйл ажиллагаанд 73,3% сайн, 23,4% дунд 3,9% хангалтгүй үнэлгээ өгсөн байна. Судалгааны үр дүнд өгсөн дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч, НЗЗ-ны 1-р байранд ажиллаж байгаа албан хаагчдаас гаргасан санал, гомдолыг тус тус хүлээн авч судлан, шийдвэрлэж ажиллах болно.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ